

ФОНТ ТАНИХ

Бат Google-д дадлага хийхээр тэнцсэн ба түүний орсон баг нь англи хэлний цагаан толгойн (a, b, c, ..., z) жижиг үсгүүдэд зориулагдан шинээр гаргасан компьютерын фонтуудыг тестлэх явдал байв.

Англи хэлний цагаан толгойн бүх 26 үсэгнүүд ядаж нэг нэг оролцсон байхаар өгүүлбэр бүтээж хэвлээд (үүнийгээ тестийн өгүүлбэр гэж нэрлэе) харж шалгадаг байв.

Батын энэ удаагийн даалгавар бол түүнд N ширхэг үгнүүд өгөгдсөн бол уг үгнүүдээ ашиглаад нийт хичнээн янзынтестийн өгүүлбэр зохиож болохыг тоолох явдал байв. Түүнд туслана уу.

Тодруулга:

($1 \leq N \leq 25$), мөн Батад өгөгдсөн үг бүрийн урт 100-аас хэтрэхгүй ба тухайн үг ямар нэгэн тест өгүүлбэрт яг нэг удаа ашиглагдана. Ямар нэгэн зохиосон тест өгүүлбэрийн үгнүүдийн байрлалыг яаж ч сэлгэсэн шинэ тест өгүүлбэр болж чадахгүй.

Оролт:

Эхний мөрөнд N буюу нийт үгнүүдийн тоо. Дараачийн N ширхэг мөр бүрт Батад өгөгдсөн үгнүүд өгөгдөнө.

Гаралт:

Зөвхөн нэг мөрөөс бүрдэх ба уг мөр нь бодлогын хариу болох ганц тоог агуулна.

Жишээнүүд:

Оролт	Оролт	Оролт
9	3	15
the	a	abcdefghijkl
quick	b	bcdefghijklm
brown	c	cdefghijklmn
fox		defghijklmno
jumps		efghijklmnop
over		fghijklmnopq
a		ghijklmnopqr
sleazy		hijklmnopqrs
dog		ijklmnopqrst
		jklmnopqrstu
		klmnopqrstuv
		lmnopqrstuvw

		mnopqrstuvwxyz
		nopqrstuvwxyz
		opqrstuvwxyz
Гаралт	Гаралт	Гаралт
2	0	8189

Тайлбар:

1-р тест дээр бүх үгнүүдээр нэг тест өгүүлбэр бүтээж болно. 2 дахь өгүүлбэр нь "а"-г хасаад үлдсэн үгнүүд нийлээд дахин нэг тест өгүүлбэр бүтэж болно.

2-р тест нь ямар ч боломжгүй. Яагаад гэвэл цагаан толгойн эхний 3-н үсгээс бусад үсэгнүүд байхгүй байна.